

АЙМГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын зорилго

1. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд менежментийн шинэ хэлбэр, дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг эзэмшүүлж иргэдийн оролцоог хангах замаар гэмт хэрэг, зөрчлийг бууруулж нийгмийн дэг журам, амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилт

2.1. Бодлогын зорилгыг хангахад дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

2.1.1. Дэвшилтэт технологид суурилсан камерын нэгдсэн системийг нэвтрүүлж “АЮУЛГҮЙ-НОГООН БҮС” бий болгож гэмт хэрэг, зөрчлийг бууруулна.

2.1.2. Эрх зүйн цахим системээр дамжуулан нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.3. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулна.

Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Аймгийн хэмжээнд “Телекамер хөтөлбөр”-ийг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.2. Цахим системийг нэвтрүүлж нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж гэмт хэрэг, зөрчлийг бууруулна.

3.4. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний чадавхыг бэхжүүлнэ.

3.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх менежментийн шинэ хэлбэрийг нэвтрүүлж зам, тээврийн осол, хэргийг бууруулна.

3.6. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх шинэ менежментийн шинэ хэлбэрийг нэвтрүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулна.

3.7. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй тэцмэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

3.8. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж, уялдаа холбоог сайжруулна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

4.1. Дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.1.1. Улс, орон нутгийн төсөв

4.1.2. Олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөр

4.1.3. Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын
удирдлага, зохион байгуулалт

5.1. Бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, санхүүжилтийг шийдвэрлэх, удирдлага зохицуулалтаар хангах үүргийг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

5.2. Бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр хангах, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн төсөвт тусгуулах, биелэлт, үр дүнг тайлагнах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн асуудал хариуцсан нэгж эрхлэн гүйцэтгэнэ.

5.3. Нутаг дэвсгэрийн хэмжээнд бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг тухайн жилийн төсөвт тусган баталж, дэмжин ажиллана.

5.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан зохион байгуулна.

5.5. Төрийн болон хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа иргэд, байгууллагын үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжинэ.

5.6. Нутаг дэвсгэртээ бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүгнэлт хийж, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын хэрэгжилтийн хяналт,
шинжилгээ-үнэлгээ

6.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн асуудал хариуцсан нэгжээс бодлогын хэрэгжилтийн тайланг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дүгнүүлнэ.

7.2. Бодлогын хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээ хариуцсан нэгж 2 тутам жил тутамд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийнэ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын шалгуур үзүүлэлт,
хүрэх үр дүн

8.1. Дэвшилтэт технологид суурилсан камерын нэгдсэн системийг аймгийн хэмжээнд нэвтрүүлж “НОГООН БҮС”-ИЙГ бий болгосноор иргэдийн аюулгүй байдал хангагдаж, цахим хяналт сайжирч, гэмт хэрэг, зөрчлийг бууруулсан байна.

8.2. Цахим системийг нэвтрүүлснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хүртээмж, чанар сайжирч, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж, хууль зүйн туслалцаа, үйлчилгээг хялбар авах боломж бүрдэж, зардлыг хэмнэсэн байна.

8.3. Урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшилж, тодорхой төрлийн гэмт хэрэг болон зөрчил буурч, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа ахиц гарсан байна.

8.4. Бодлогын зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг дараах байдлаар үнэлнэ.

**ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН**

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2024 он)	Зорилтод түвшин, үр дүн				Санхүүжилтийн эх үүсвэр	Хариуцах байгууллага	Хамтран оролцох байгууллага, албан тушаалтан
					2025	2026	2027	2028			
1	Дэвшилтэт технологид суурилсан камерын нэгдсэн системийг нэвтрүүлж "АЮУЛГҮЙ-НОГООН БҮС" бий болгож гэмт хэрэг, зөрчлийг бууруулна.	Телекамер хөтөлбөрийн хэрэгжилт	Хувь	Хөтөлбөр батлагдсан	50%	70%	90%	100%	Улс, орон нутгийн төсөв төсөл хөтөлбөр	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс	-Сумын иргэдийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар -Төрийн бүх шатны байгууллага -Хууль сахиулах болон тусгай чиг үүргийн байгууллага -Иргэний нийгмийн байгууллага
2		Камержуулах сум	Тоо	Зуунмод сумын 35 цэгт	1 Зуунмод	9	18	27			
3		Улс болон орон нутгийн замд дундаж хурдны камер нэвтрүүлсэн сум	Тоо	-	Зуунмод Сэргэлэн	Баян Лүн	Баянчандмань	Эрдэнэ			
4		Гэмт хэргийн бууралт	Хувь	535 гэмт хэрэг гарч өмнөх оноос -23.3%	-2%	-3%	-4%	-5%			

											-Иргэд, олон нийт
5	Эрх зүйн цахим системээр дамжуулан нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Цахим системийн ашиглалтын хувь	Хувь	5%	10%	20%	30%	40%			
6		Цахим эрх зүйн хөтчийг сургуулийн орчинд нэвтрүүлсэн тоо	Тоо	Судлагдаж байгаа	2 сургууль	5	8	10		Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс	-Хууль зүйн үндэсний хүрээлэн -Төрийн байгууллага -СУмын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль
7	Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг	Арга хэмжээ	Тоо	10	20	30	40	50		Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх	-Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, - Гэр бүл, хүүхэд,
8		Хамрагдсан иргэд	Тоо	1000	2000	3000	4000	5000			
		Тодорхой төрлийн	Хувь	-1%	-2%	-3%	-4%	-5%			

	дээшлүүлж, гэмт хэргийг бууруулна.	гэмт хэргийн бууралт								зүйн хэлтэс, Цагдаа гийн газар	хөгжил, хамгаалл ын газар -Сумдын ГХУСАЗЗ, Хамтарса н баг
--	--	----------------------------	--	--	--	--	--	--	--	--	---

...оОо...